

**АГВААНДАНДАР ЛХАРАМБЫН “ГАНЦААС ХАГАЦСАНЫ
АГУУЛГА САЙТАР НОМЛОЛЫН ДАЛАЙГААС ТҮҮВЭРЛЭСЭН
ЭНДҮҮРЛИЙГ ТЭВЧИГЧ РАШААНЫ САЦАЛ ХЭМЭЭХ ОРШВОЙ”**

/Төвд хэлнээс МУИС-ийн Шашин Судлалын Тэнхимийн
докторант Д.Лувсанжамц орчуулав/

Цаасны төрөл: Төвд

Цаасны хэмжээ: 8X52 см

Бар: Гүнбүм

Эрхэм зарлигийн увдисын далайг эрхэндээ оруулсан
Энгүй оюун сайт долоон цогнойлт төгөлдөр
Буяны садан чадагчийн шашны далайн эзний өлмий
Гурван орны амьтдын оройд ялгуугтун.
Сайтар номлогч хэл, хурц ухааны гох бээр
Сэтгэлийг хөдөлгөгчийн эрхэт оюуны эндүүрлийн зааны чуулганыг
Сайн номын мөрд оруулахдаа мэргэн жолоодогч
Садан дээдийн өлмийд гарын лянхуаг хумимуй.
Хэдүйчинээ мэдэгдхүүний оршихуйн ёсыг ямар мэтээр нь
Ойлгоход хялбар хэлээр увидаслан зохиосон бүтээлийн эрхэт
Оюун сайтын өнө ёсыг тэтгэсэн цог
Хайнцашгүй багш бээр ёс үүнийг өлзийгээр тэтгэ.
Үнэхээр бүтээгүйг нотлогч ухааны тэнгэрийн мөрийн энг
Миний оюуны зөгий бээр хэр хэмжээг мэдэхийг хүсэвч
Тэр ямагтыг ажиглахын жигүүрийн хүч ихэд дорой учир
Чинадад хүрэхийн горил нь өрөөслөн тасарчээ.
Тэгэвч олон мэргэдийн сэрүүцүүлэгчийн мөрийг даган нэхэж
Тэдгээрийн сайтар номлолын аман захиасын дөрвөн эрдэмд шүтэж
Ихэд ажиглалын таягаар тааллын хэмжээг босгоод
Энд өчүүхэн өгүүлье, оюун төгөлдөрүүд чихээ тос.

Тэгүүн дор энд ганцаас хагацахын учир шалтгааныг номлон үйлдэх дор

- НОТОЛГООНЫ ХОРИГДХУН ЛУГАА АЖИГЛАХ
- ҮҮНИЙГ ИЛБИЙН ҮЛГЭР ЛУГАА НАЙРУУЛАХ ЁСОН ДОР АЖИГЛАХ
- ИЛБИЙГ ЧИНАГШ АГУУЛАН ҮЙЛДЭХ ШАЛГАДАГ УХААН ДОР АЖИГЛАХ
- ИЛБИЙН МОРЬ ҮХЭР ТЭРГҮҮТЭНИЙ МӨН ЧАНАРЫГ АЖИГЛАХ
- ХОРИГДХУУН ЭРХТЭНИЙ МЭДЭЛД ҮЗЭГДЭХ, ЭС ҮЗЭГДЭХ ДОР АЖИГЛАХ
- ХОРИГДХУУНЫГ НЯЦААХ УЧИР ШАЛТГААН БОДТОЙГ НОМЛОХ

лугаа зургаа болой.

Нэг. НОТОЛГООНЫ ХОРИГДХУУН ЛУГАА АЖИГЛАХ

“Төвд орохуйн тийн номлол тааллыг машид тодруулагч”-аас:

Амьтны шунал нь суурь эгүүнд хоригдохуун тэр нь утга бусдад байгаагаар барих бус
суурь нь өөрөө хоригдохуун түүний мөн чанарт шунах тул...хэмээн зарлигдсан адил
бид нар өөрийн талаас бүтсэн баттай харагдах уул, байшин, гэр тэргүүтэн тэдгээр

өөрсдөө хоригдохоос бус хоригдохуун эвэртэй өөр нэгийг бусдад хайваас машид эндүүрэл мөн бөгөөд Жанжаа Ролбийдоржийн *"Үзлийн дуулал"*-аас: Сүүмэлзэх үзэгдлийг хэвээр орхиод хоригдохуун эвэртэн нэгийг хайх дор үзэгдэх бөгөөд... хэмээн зарлигласан бус уу.

Эгүүн дор зарим нэгэн энэ нь өөрөө зохис үгүй эгэл төрөлхийтөнд ямар мэт үзэгдэх уул, байшин, гэр тэргүүтэн эрхтэний мэдлийн баригдахууны орон мөн учир түүнийг бүхий л нөхцөлд хорих нь зохисгүйн тулд бөгөөд *"Их үлэмж үзэхүй"*-гээс: Эрхтэний мэдэл тэргүүтэн атгаг үгүй мэдлийн баригдахуун бүгд нь хэзээд учир шалтгаанаар үл сөгөөгдөх болой хэмээн зарлигласны тулд хэмээвээс энэ нь үнэн боловч атгаг үгүй мэдлийн үзэгдлийн суурь тэр нь атгагаар үнэнхүйд шунах суурь мөн учраас түүний дээр хоригдохуун өөрийн зүгээс бүтсэнд харагдах нэгэн хувь ба эс хоригдохын үзэгдэл төдий хувь хоёр байгаа нь үзлийг эс олохыг хүртэл тэр хоёр нэгд холилдон үзэгдэх бөгөөд хэзээ үзлийг олохын үед тэр хоёрыг тус тусад нь ялгах бөгөөд үзэгдэл төдий үл няцаагдах аньс нэг байгаа нь мэргэдийн зарлигаас алдаршсан учир тиймээс эгэл төрөлхийтөнд уул, байшин, гэр тэргүүтэн үзэгдэх нь тэдгээр нь хувь бүхнээс өөрийн зүгээс бүтсэнд харагдах үзэгдэх ёс байгаад тэр нь буцаад өөрийн оюуны үүднээс хувь бүгдээс хоривоос одоо түүний оромд юу ч байхгүй боллоо хэмээн аймшгийг эс төрөхийг хүртэл бясалгаж үйлдээрэй. Айн жигээрэмших тэр адил төрөх нь ч машид ховор бөгөөд Хайдавжийн *"Элдэв зарлиг харанхуйг арилгагч зул"*-аас: Гүнзгий хоосон чанар лугаа айн жигээрэмших бодитой төрөхийн ёс ирэхийн завсарт хүрэх нь ч машид бэрх болвоос хоосон чанарын ойлгоцыг амсахыг хүрэхийн баттай мэдэл чанх зөв буйн хязгаар эцэс төдийд хүрэхийг хэлээд яах вэ гэдэг нь ч хэрэг юун хэмээн зарлигласан. Тийм учраас өөрийн зүгээс бүтэх ёсны ерөнхий утга төдий ч эс ургах одоогийн билиг чанарын номыг судлаачдаас урьдын хоригдохууныг ихэд түгэлтийг баримтлаач нар нь илүү чухал болсон нь мөн болой. Хоосон чанараас эс айхын шалтгаан хоёр байх бөгөөд эсвэл хоосон чанарын дуун утга алиныг ч эс мэдэх тэнэгүүд эс айх бөгөөд түүний гэм эрдэм алиныг ч эс мэдэхийн тулд болой. Жишээлбээс мориноос унахыг эс мэдэх тэнэг бээр догшин морийг унана хэмээн эрэмшихтэй адил юм. Эс бөгөөс хоосон чанарын илтэд үзвээс эс айх бөгөөд айхын шалтгаан үнэнхүйд барих үзэх мөрийн хоригдохуун нисваанис байхгүй учраас. Жишээлбэл: эмнэг морийг номхотгохын арганд сайтар суралцсан төрөлхийтөн лугаа адил болой. Тэгвэл хэн айх вэ хэмээвээс юмс үүнийг байх байхгүй дор ажиглалыг үүсгээд хоосон чанарт өчүүхэн төдий ойлгоход айдас төрөх нь зохистой. Учир нь түүний сэтгэлийн талаас гэнэт юмс алин бээр ч байхгүй мэт сэтгэлд ургах учраас. Жишээлбэл догшин морийг унах ёсыг өчүүхэн төдий мэдсэн боловч эцэст нь хүргээгүй төрөлхийтөн лугаа адил болой. Үүнд *"Төв үзлийн дөрвөн зуут"*-аас: Эс үзсэн нь эс айх бөгөөд үзвээс байдал бүхэнд түүнээс буцахуйд болно. Тиймээс магадтай өчүүхэн төдий нэг мэдэхүй дор айдас буй болж үйлдэнэ хэмээн зарлигласан болой. Хэтрүүлэгч төв үзэлтэн мэт болвоос өөрийн билэг чанараар бүтсэн гэх, өөрийн мөн чанараас оршиж байгаа зэрэг нь зөв нотолгооны хоригдохуун (няцаагдахуун) мөн учраас өөрийн билэг чанараар бүтсэн тэргүүтэн тэдгээрийн утга нь өөрийн эрхээр бүтсэний утга мөн хийгээд тэрхүү өөрийн утгаар бүтсэний утга нь бусдаас үл харгалзахын утга мөн болой. *"Их үлэмж үзэхүй"*-гээс: Өөрийн эрхт нь өөрийн чанараас бүтсэнд харагдах үед мэдэл тэдгээр нугуудад бусдаас эс харгалзан оршихоор мэдрэгдэх бөгөөд мэдрэгдсэнчилэн бүтсэний утга болой... хэмээн зарлигласны тулд. Тиймээс суурьт бүтсэний хэмжээ нь бусдад үл харгалзах мөн учраас алтан хумх адил нь ч бусдаас үл харгалзах мөн буюу, тийм

болой, тэр нь амьтан нугуудын буянд харгалзах мөн учраас. Амьтан нугуудын буян их байх цагт тэр нь алтан мөн. Амьтдын буян аажмаар барагдахын цагт мөнгөн хийгээд зэсэн болох зэргээр хувиран оддог болой. Жишээлбэл: Бярман Маргандаагийн алтан бумба мэт болой. Тэр ямар адил болов хэмээвээс Маргандаагийн хүү нэгэн бярманы гэрт алтан хумхаа орхиод олон мянган жил өнгөрсөний хойно эргэн ирээд урьд үлдээсэн алтан хумхаа авахад алтан хумх нь мөнгөн хумх болж өөрчлөгдсөнийг хараад дахин урьдахчилан орхисноор аажмаар зэс хийгээд төмөр хумх болон хувирсан түүх *"Дөрвөн зуутын тайлбар"*-т гардаг мэт болой. Мөн бас *"Их үлэмж үзэхүй"*-гээс: Орны дээр өөрийн чанарын үүднээс өөрөө дангаар оршин чадахын байдалтай ёсыг өөрийн эрхт хэмээн үйлдээрэй... хэмээн зарлигласан адил өөрийн эрхээр бүтвээс орны дээр өөрөө үнэхээр оршин чадах нэг хэрэгтэй учраас. Тиймээс эгэл хүмүүн нугуудад харагдах их мөрөн номт. Тэрний орны дээр ус мөнд өөрөө эс оршихуй Тэр нь ус мөн нь бодгаль бусдын үйл лугаа харгалзах учир буюу. Тэр нь амьтан зарим нэгний үйлд харгалзан ус мөн боловч байдал бүхэнд ус мөнд үнэхээр эс орших буюу. Ус түүний захад үйлт бэрдүүд олноор цуглахын цагт гагц идээ бээрт урвах буюу эс бөгөөс эрэг түүний дотор усан дусал нэгээхэн ч үгүй хуурай хайрга бий болох учраас. Түүнчилэн сав шим бүхэн үйлд харгалзах мөн буюу. *"Авидарма"*-аас: Үйлээс элдэв орчлонд төрөх... хэмээн зарлигласны тулд. Тиймээс өөрийн эрхтэйд бүтсэн тэргүүтэн нотолгооны няцаагдахуун мөн хэмээн хэтрүүлэгч төв үзэлтэн таалах болой. Харин *"өөрийн үндэстэн"* хэрхэн ам авах вэ хэмээвээс цогт Сажийнхан тэргүүтэн урьдын мэргэдүүд – Өөрийн үндэстэн төв үзэлтэн номт. Өөрийн билгэ чанараар бүтсэнд ам эс авах буюу төв үзэлтэн мөнийн учир түгэх бөгөөд *"Төв үзлийн үгийн тайлбар"*-аас: Төв үзэлтэн мөн болвоос өөрийн үндэснээс үйлдэх нь зохисгүй гэж зарлигласан учраас... хэмээжээ. Их богд Зонхов бээр тэр адил эс таалах буюу хумх байваас өөрийн билгэ чанараас бүтсэн ам авах нь зохисгүй тул ам авах нь зохисгүйд албатай боловч өөрийн билгэ чанараар бүтсэнд ам авсан төв үзэлтэй байх нь эс харшлах буюу. Жишээлбэл санваар төгөлдөр гэлон нь санваар лугаа харшлах зохисгүй нь албатай боловч цааз лугаа харшилсан гэсэн байдагчлан өөрийн үндэст тогтсон таалалтан бээр өөрийн билгэ чанараар бүтсэнд ам авах нь зохисгүй болох биз. Гэвч тэрээр өөрийн билгэ чанараар бүтсэнд ам авах бөгөөд *"Билгүүний зул"*-аас: Хэрвээ дүрс хэмээн сэтгэлдээ өгүүлэх болон үгэнд өгүүлэхийн бүхэнд нэрийдэх чанар алин мөн хир нь байхгүй болой хэмээвээс бодот лугаа хочлол тавьсан болох бөгөөд сэтгэлдээ өгүүлэх үгэнд өгүүлэхэд хочлол тавьсаны тулд болой... хэмээн зарлигласны тулд албатай бөгөөд *"Таалалын тайлбар"*-аас бүхэнд нэрийдэх билгэ чанар мөн чанар ямагт бөгөөд номлосны бүхэнд нэрийдсэн тэр нь чанар хийгээд ялгамжаанд сэжигдэхийн нэр хийгээд атгагт үйлдвээс тэр хоёр нь бусдын эрхт мөн учраас бусдын эрхтэт билгэ чанар, мөн чанар үгүйд номловоос хочлол талбихуй болоход хочлол талбисан болно хэмээн номлосон хэмээх учраас мэдэн чадах болой хэмээн номлож үйлдэх дор *"Сайтар номлолын зүрхэн"*-ээс: Нэрийтгэлд байгаа дор ч бас түүний мөн чанар ямагт хийгээд өөрийнхчилэн ба түүний өөрийн билгэ чанар тэргүүтэн дор хэтрүүлэгч төв үзэлтэний гол номд номлосон нь ч олон. Өөрийн мөн чанар ямагтаас эс бүтсэн хийгээд мөн чанараас эс төрсөн хийгээд эд дор эс бүтэх тэргүүтэн ловон түүний гол номд ч олон байх тул ялгахад төвөгтэй харагдахнаа нь ч *"Тааллын тайлбар"*-т зарлигласан билгэ чанар мөн чанар ямагт байх байхгүйн утгыг номлосон тэр ямагт ловон тэрбээр бодот дор өөрийн билгэ чанараас бүтэхийн нэрийтгэл дор таалахын хамгийн тодорхой эх сурвалж мөн болой хэмээн зарлигласны тулд тиймээс *"Билгийн*

зул"-ын ишлэл түүнээс бусад өөрийн үндэст төв үзэлтний ном бусдад өөрийн билиг чанараас бүтсэнийг нигуураараа болгоосон нь тодорхой үгүй болой. Гэвч Хайдавжий бээр ухаанаар бүтээх ёс нэгийг зарлигласан бөгөөд *"Донтүн"*-аас бас Ловон Лигдэнжидийн ёсон дор бодот нугууд нэрийтгэл төдийд өөрийн билгэ чанараас үгүй хийгээд мөн чанар үгүй хийгээд өөрийн мөн чанараас эс бүтсэнд таалваас нэрийтгэл төдий бодит нугууд эд дор эс бүтэхэд таалах хэрэгтэй бөгөөд эс бөгөөс эд байх хийгээд нэрийтгэлд байх хоёр эс харшлан хэтийдэхийн тухайд хийгээд эдэд бүтсэн дор чанар үгүйд баримтладаг гадаад дотоодын тогтсон тааллыг өгүүлээч хэн ч байхгүйн тухайд болой хэмээн зарлигласны тулд. Энд өөрийн үндэстний тогтсон таалалтныг суурьт барихын үест: Хумх номт. Өөрийн зүгээс бүтсэн юмаа. Өөрийн мөн чанараар бүтсэн учраас. Зөвшөөрвөөс өөрийн чанар ямагтаас бүтсэн юмуу. Зөвшөөрсөн буй за. Зөвшөөрөн үйлдэхүй дор: Бусад нэгэн: Энэ нь зохис үгүй. Өөрийн үндэстэний тогтсон таалалтан бээр хумхыг мөн чанар ямагтаас эс бүтсэнд зөвшөөрөх хэрэгтэйн тухайд буй. Тэр нь мөн чанар ямагт үгүйд өгүүлдэг тогтсон таалалтан мөн учраас. *"Их бодь мөрийн зэрэг"*-ээс: Өөрийн үндэстэний тогтсон таалалтныг ч мөн чанар ямагт үгүйсгэн өгүүлэгч хэмээдэг болохноо нь ч... хэмээн зарлигласан бус уу хэмээвээс ажиглаж үйлдээрэй. Тийм учраас өөрийн үндэстэний тогтсон таалалтны үест өөрийн бэлгэ чанараас бүтсэнийг хорин үйлдэх нь зохисгүй учраас үнэхээр баттай бүтсэнийг хоригдохуунд үйлдэх хэрэгтэй бөгөөд үнэхээр баттайд бүтэхийн ёс тэгүүн дор хоёр байна. Үнэхээр баттайд ажиглах ухаан мэдэл дор үнэхээр баттайд үйлдээд түүний зүгээс байгаа нэг хийгээд оюуны эрхээр тавихуй дор эс харгалзан өөрийн билгийн орших ёс дор бүтэх гэх мэт хоёр байна. Урд талын буйд барих нь үнэнд барих бүхэнд нэрийдэхийн барих ёс хийгээд дараагийн буйд барьж буй нь үнэнд барих хамтад төрсний барих ёс мөн учраас үнэхээр эс бүтсэнийг бүтээхийн үест хойдохыг нь голлон няцаах хэрэгтэй бөгөөд үнэхээр эс бүтсэнийг бүтээхийн хэрэг нь орчлонгийн ёзоор дор хорлохын тухайд мөн болой. Товчилвоос өөрийн үндэст тогтсон таалалтаны ёсны эцсийн хоригдохуун нь оюун дор үзэгдэхийн эрхээр эс тавигдан оршихуйн ёсны зүгээс бүтээхүйд үйлдэх нь мөн. *"Төв үзлийн гэгээ"*-ээс: Тийм учраас тэдгээрийн санааны эрхээр бодот хуурамч мөн чанарт бүгд нь янагуухд орших ямагт болой хэмээн зарлигласны адил мөн учраас. Энд хэрвээ *"Төв үзлийн гэгээ"*-ээс өөр өөрийн үндэстэн төв үзэлтэний ном бусдад хоригдохууныг танин барих нь тодорхой гараагүй юмуу *"Төвд орохуйн тийн номлол тааллыг машид тодруулагч"*-аас өөрийн үндэстэн төв үзэлтэний ном гарал үүсэл болж чадах бусдаас хоригдохууныг танин барих тодорхой эс гарсан дор *"Төв үзлийн гэгээ"*-ээс янагуухд оршихуйн ёсыг номлосны чанх эсрэг зүгт оршин байгаа нь үнэхээр утга баттай буюу үнэхээр байгаа дор мэдсэн учраас хэмээн зарлигласан шүү дээ хэмээвээс. Алба үгүй. Урд номлосон адил утга баттайд ажиглахын ухаан мэдлийн зүгээс оршин байгаад утга баттайд оршоноор агуулж буй нэг хийгээд оюуны эрхээр тавих дор эс харгалзах өөрийн билгээр орших ёсон дор бүтээх хоёроос сүүлийнх нь *"Төв үзлийн гэгээ"*-ээс бусдад гарсан нь байхгүй ээ хэмээсний утга мөн болой. Зөвшөөрөн эс чадах. *"Сайтар номлолын зүрхэн"*-ээс: Энд бас газар тэргүүтэн утга баттайгаас гарахын мөн чанар ямагт бус... хэмээн зарлигласны тайлбар нь *"Догз барва"*-аас: -Хэмээснээс тэр адил болвоос төв үзэлтэн хийгээд бусад нугууд байгаа үгүйг ажиглахын суурь тэр нь утга баттайд үгүй хэмээхийн утга нь суурь тэр нь утга баттайд ажиглахын ухааны зүгээс байхгүй бөгөөд түүгээр ч эс бүтэх... хэмээн зарлигласан учраас. Үнэхээр эс бүтсэнийг нотлон буулгахад алин

үгүйсгэгдэхүүний үнэхээр байгааг анханд танин барих хэрэгтэй бөгөөд жишээлбэл ходоод цүндгэрт хумх хэмээхийн томъёог найруулж чадах бодгалд хумх байхгүй болой хэмээн өгүүлбээс ходоод цүндгэрийг үгүйсгэхийн утгын ерөнхийлөл сайтар ургаж чадах боловч ходоод цүндгэр зүйлд хумх хэмээхийн томъёог найруулж чадахгүй бодгалд хандан хумх байхгүй байна хэмээн өгүүлэвч "хумх байхгүй байна" хэмээх дууны ерөнхий төдийгөөс хоригдохуун ямар адил нэг байхгүйн утгын ерөнхийлэл ерөөсөө ургах учир байхгүй мэт болой. Зохист ухааны хоригдохуун байхад буй бус байх хэрэггүй. Учир нь үнэнд баригч болон түүний барьсны дагуу бүтэхүй хоёулаа зохист ухааны хоригдохуун мөн тул "Их үлэмж үзэхүй"-гээс: Чанх буруу баригчийг хоригдохуун хэмээн зарлигласан хийгээд түүний барьсан мөн чанар буйг хоригдохуун хэмээн номлосон хоёр буй болой... хэмээн зарлигласан юм. Хэрвээ хумх буй бус нь ч үнэмлэхүй /үнэн зөв/ нотолгооны хоригдохуун мөн үү? Хумх хуурмаггүй ухааны зоригдол мөний нотолгоогоор хумх буйд нотлох үнэн зөв нотолгооны хоригдохуун мөн шүү дээ хэмээвээс албагүй гэх хэрэгтэй юмуу. Зөвшөөрвөөс даган үлихүйн хоригдохуун мөн үү? Зөв нотолгооны хоригдохуун мөн шүү дээ. Зөвшөөрч чадахгүйн учир нь даган үлихүйгээр нотлогдох тул. Тэр мөн шүү дээ даган үлихүйн мэдэгдэхүүн мөн тул. Бас зарим нэгэн хэлэхдээ: даган үлихүйн хоригдохуун байж болно шүү дээ, Томъёололыг шинжлэн үйлдэгч даган үлихүйн хоригдохуун буй бөгөөд дээд утгыг шинжлэн үйлдэгч дагн үлихүйн хоригдохуун ч байгаа тул хэмээвээс, Албагүй. Албатай шүү дээ, Тэр хоёрт үл багтах даган үлих байхгүй тул хэмээвээс мөн л албагүй. Түүнчлэн хумхыг томъёололд буй бус гэж барьсан оюун номтоо. Томъёололыг шинжлэн үйлдэгч ухаан мэдлийн хоригдохуун мөн юмуу, хумхыг томъёололд оршин буйд оносон ухаан мэдлийн хоригдохуун мөн тул хэмээвээс албагүй. Зөвшөөрч чадахгүйн учир нь томъёололыг шинжлэн үйлдэгч ухаан мэдлийн олсон утга мөний тул. Бас хумх буй бус номтоо, эрхтэний илт мэдлийн орон бус юмуу, өчүүхэн далд болохуй мөн учраас анхдугаар ажиглалын орноос хэтэрсэн мөн тул хэмээвээс албагүй. Зөвшөөрч чадахгүй шүү дээ, эрхтэний илт мэдлийн орон мөн тул шүү дээ, түүний далд орон мөний тул болой. Анхдугаар ажиглалын орон бус хэмээх нь түүний үзэгдэлийн орон биш гэсэн утгатай болой. Хумхаар хоосорсон газрыг барьсан эрхтэний илт мэдэл тэр нь хумх буй бус-д хуурмаггүй ухаан боловч, түүнд илт мэдлийн шалгадаг болон даган үлих шалгадаг болох нь бус болой. Хоригдохууныг хорих ёс нь ч дээд утганд үгүй, үнэнд үгүй хэмээн байгуулах нь ихэд алдартай ч гол номлолын утга нь дээд утгыг ажигласан ухаан мэдэл болон тэр адилаан тэгш агуулсаны хувьд буй хийгээд түүний хувьд төрөхүй тэргүүтнийг няцаах хэрэгтэй бөгөөд тэр мэт хэрэгтэйн учир шалтгаан нь: дээд утганд байх аваас тэр мэт байна уу үгүй юу хэмээн ажигласан ухаан мэдэл бээр олох хэрэгтэй байтал тэр бээр тэр мэт эс олсон тул дээд утганд эс бүтсэн болой хэмээн өмнөөс эсэргүүцэгч бээр тэр төдийг бүтээхийг хүссэний тулд болой.

Хоёрт. ХОРИГДХУУНЫГ ИЛБИЙН ҮЛГЭР ЛУГАА НАЙРУУЛАХ ЁСОН ДОР АЖИГЛАХ

Илбэчин бээр нэгэн чулууг морь болгон хувилгах цагт илбэчинд чулуу морь болон үзэгдэх байвч шунах байхгүй, нүдээ ховсдуулсан үзэгч түүнд морь болон үзэгдэх, шунах хоёулаа байна, тэр газар хожуу ирсэн хүмүүст үзэгдэх, шунах хоёулаа байхгүй түүнчлэн хоосон чанарыг утгын ерөнхийн ёсоор мэдсэн эгэл төрөлхтөн болон хоосон чанарыг эс мэдсэн эгэл төрөлхтөн хийгээд хоосон чанарыг илт мэдлээр оносон хутагт гуравт дэс дараачлан үнэнээсээ бүтсэнд үзэгдэх байвч шунал үгүй хийгээд

үзэгдэх шунах хоёул байх болон байхгүйн үлгэр утгыг учруулах, илбэчин ба нүдээ ховсдуулсан үзэгч хоёуланд /илбийн/ чулуу морь болон үзэгдэвч үзэгдэх ёс нь адилгүй юм. Учир нь тэр үед илбэчинд чулуу морь болон үзэгдэх тэр нь дотоод оюуны эрхээр тавигдсан орших ёсонд ургахаас оюунд харгалзахгүйгээр чулуу өөрийн ашидын уг шалтгаанаар үүссэн оршихуй бусаар ургах бөгөөд үзэгчдийн хувьд дотоод оюуны эрхээр тавигдсан орших ёсонд ургалгүй, тэр байранд жинхэнэ морь буйн эрхээр тавигдсан оршихуйд ургах болой. Ер нь оршихуйн ёсонд галны халуун мэт угийн ойр авлын уг шалтгаанаар үүссэн оршихуй ёс, галд улайссан моголцог төмөрний халуун мэт гадны хавсран үйлдэх шалтгаанаар шинээр засварласан оршихуй ёс, арвис тарнийн хүчээр улайсан бадарсан моголцог төмөрний дээрх халуун бус хүрэлцэхүй мэт дотоод оюунаар засварласан оршихуй ёс мөний адил илбийн үзэгдэл энэ нь ч оюунаар засварлагдсан оршихуй ёс мөн учраас оюунаар засварлагдах ёс нь: арвис тарничин болон илбэчин хоёрын сэтгэлийн мухарт улайсан бадарсан моголцог төмөр тэр бээр үл түлэх болой хэмээсэн бодол хийгээд энэхүү чулуунаас морьны үзэгдэл булзааралтгүйгээр ургах болой хэмээх бодол хоёр сэтгэлийн угаасаа буй хийгээд тэр хоёр бодол бээр ямар мэт шунасаны дагуу утгандаа ч хуурмаггүй юм. Оршихуй ёс тэдгээр ч шалгадаг ухаанаар нотлогдох мөн учраас дээс могойд үзэгдэх болон чулуу моринд үзэгдэх хоёр адилхан эндүүрсэн боловч эндүүрэх ёс нь ерөөсөө адилгүй тул *"Орохуйн тийн номлол таалалыг машид тодруулагч"*-аас: Үлгэрлэвээс дээсийг могойд эндүүрэх цагт ухаан түүний хувьд дээс могой мөн хэдий ч ер нь могой биш хэмээн хэлдэг мэт ухааны эндүүрлийн хувь төдийд адуу үхэр болон үзэгдсэн хэдий ч ер нь хувилагдхууны суурь адуу үхэр болон үзэгдэхгүй хэмээн үйлдэж болохгүй. Ялгаа тэр мэт эс найруулавч хувилгааны суурь адуу үхэр болон үзэгдэнэ гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй тул... хэмээсэн хийгээд *"Донтун"*-гаас ч: -Тэр нь ч илбийн хувилгааны суурь эндүүрсэн ухааны хувьд адуу үхэр болон үзэгдэх мөн боловч ер нь илбийн хувилагдхууны суурь адуу үхэр болон үзэгдэхгүй хэмээж болохгүй бөгөөд... хэмээн зарлигласан шүү дээ. Тиймээс Богд эцэг хөвгүүд бээр дээсийг могой болгон харах цагт дээсний талаас могойн үзэгдэл үүсэх эс үүсэхэд сэжиг таслахыг хайрлалгүй, чулуу морь болон үзэгдэх цагт яавч чулууны талаасаа үзэгдэх хэрэгтэй хэмээн их шамдалаар нотолсоны гол хэрэг нь гэгээ лугаа хагацсан харанхуйд мушгирсан эрээн олс алин байгаа түүнд могойн үзэгдэл ургасан тэр нь дээсний оршихуй ёс бус, гадны шалтгаан харанхуйн эрхээр ургасан мөн хийгээд тарнийн зай лугаа хагацсан чулуу хэдий чинээ байвч морьны үзэгдэл үл ургах тэр нь чулуу өөрийн ашидын уг шалтгаанаас үүссэн оршихуй ёс мөн хийгээд тарнийн зайгаар ховсдуулсан чулуу хэдий чинээ түүнд морьны үзэгдэл ургах нь оюунаар засварласан оршихуй ёс тусгай нэгэн байгаа түүнийг мэдүүлэхийн тухайд мөний тулд болой. Цөвийн цагийн бүхнийг болгоогч Жанжаа ринбуучээ бээр *"Чадагчийн шашин цогцолсоны үзэсгэлэнт чимэг"* хэмээх номонд -Гэвч тарнийн зайгаар буртаглагдсан оюуны эрхээр тавигдсан чулуу мод өөрийн талаасаа адуу үхэрт үзэгдэх оршихуй ёс нэгэн байх хэрэгтэй болой... хэмээн зарлигласан мэт болой. Товчилвоос дээс могой мөнийг буруу мэдлээр агуулах хийгээд чулуу илбийн морь мөнийг шалгадаг ухаанаар агуулахын аньсаар мөн учраас ойлгох ёсыг бүдүүвчлэн үйлдвээс илбэ хувилгах үеийн чулуу тэр нь илбийн морьны мөн чанар болсон мэт нэгийг ойлгох хэрэгтэй юм. Тэр үнэн болвоос *"Шалгадагийн их тайлбар Ухааны далай"*-гаас: -Хэрвээ түүний олон шавар ямагт адуу үхэр байхгүйгээр адуу үхэрт үзэгдэж буй биш боловч илбийн тарнийн зайны эрхээр адуу үхрийн мөн чанарт төрөөд адуу үхэрт үзэгдэж буй мөн хэмээвээс тэр нь үл таарах бөгөөд... хэмээн

гарсан лугаа ч үл харшлахын учир нь энэ нь олон шавар ямагт жинхэнэ морьны мөн чанарт одоогүй хэмээсэн утга төдий мөн болно. Ранжүдба бээр бүх юмсыг хорлолгүй оюунд үзэгдэхийн эрхээр орших төдийд үзэх боловч оюунаар агуулагдах төдийд үл үзэх хийгээд хорлолгүй оюунд үзэгдэхийн эрхээр орших төдий хэмээх төдийн дуугаар ч өөрийн талаас бүтэхийг үл таслах нь илбэ үзэгдэх цагт чулуу морь болон үзэгдэх тэр нь дотоод оюунаар агуулагдсан оршихуй ёс мөн учраас байгаа мөн хийгээд байх ёс тэр нь ч чулуу дангааранд нь тэр мэт үзэгдэлийг төрүүлэхийн хүч байхгүй боловч тарни эд тэргүүтний шүтэн барилдлага чуулсан чулуу ямагтад байгаа учраас илбийн морь нь хувилгаднууны суурь чулууны талаас бүтэх мөн учраас нэрийтгэлийн суурийн талаас бүтэх хийгээд өөрийн талаас бүтнэ хэмээн үздэг юм. Түүнчлэн судар аймгийн явдалт ранжүдбийн ёсонд ч оюунд үзэгдэхийн эрхээр бүтэх төдий хэмээхийн төдийн үгээр гадны утгыг үл таслахын ёс түүгээр жишээд мэдэж үйлдээрэй. Түүнд: Тийн болгоогч номтоо. Үнэнд бүтэх үү? Хорлолгүй оюунд үзэгдэхийн эрхээр орших төдий бус өөрийн талаасаа бүтсэн шүү дээ. Тэр мөн юмаа. Бага төрөлхтөний үндсэний хорлолгүй оюунд үзэгдэхийн эрхээр орших төдий бус өөрийн талаасаа бүтсэн мөн шүү дээ. Тэр мөн юмаа. Бага төрөлхтөний үндэсний хорлолгүй оюунд үзэгдэхийн эрхээр орших бус хийгээд өөрийн талаасаа бүтсэн мөний тулд хэмээвээс энд албагүй хэмээн хариулна. Тэр нь ч судрын аймагтан нар бээр өөрийн чанартнуудыг илт мэдэлд үзэгдэхийн эрхээр агуулна хэмээх болон ранжүдба бээр өөрийн бэлгийг хорлолгүй оюунд үзэгдэхийн эрхээр оршино хэмээх хоёр адилгүй бөгөөд судрын аймагтан бээр өөрийн бэлгийг илт мэдэлд үзэгдэхийн дагуу бүтэх нь өөрийн бэлгийн эцсийн оршихуй мөн учраас тэр дээд утганд байгаа мөн хэмээжээ. Өөрийн үндэст бээр юмс бүхэн хорлол үгүй оюунд үзэгдэх боловч үзэгдэл тэр нь эцсийн оршихуй бусаа. Юмсын эцсийн оршихуй ёс нь утга баттайд эс бүтсэн мөний тулд болой хэмээжээ.

Гуравт. ИЛБИЙГ ЧИНАГШ АГУУЛАН ҮЙЛДЭХ ШАЛГАДАГ УХААН ДОР АЖИГЛАХ

Ерөнхийдээ өөрийн үндэстийн ёсонд юмс бүхэн хорлол үгүй оюунд үзэгдэхийн эрхээр байгаад агуулах бөгөөд оюунд үзэгдэх төдийгөөр байгаад агуулбаас эрээн дээс могой мөн нь буйд болох тул энэ учир хорлол үгүй оюун хэмээн өгүүлсэн болой. Хорлол үгүй нь хөндлөнгийн эндүүрэлээр эс түйтгэрлэгдсэн дор үйлдэх юм. Илбийн морь ч байгаа тул оюун хорлол үгүйн эрхээр байгаа хэмээх хэрэгтэй. Тэр нь чулууг моринд хувилгасан мэтээр жишвээс чулуу тэгүүнд эм хийгээд элдэв зай тэргүүтэй юу хэрэгтэй бүхнийг талбиад хэдий хэмжээний хэрэгтэй тарни нугуудыг уривч илбэчин өөрөө ч нүдээр эс харах. Орон энд нүд нь түйтгэрлэгдсэн үзэгч нэгэн байхгүй үед одоо илбийн морь байхгүй мөн. Нэгэн цагт илбэчин өөрөө буюу нүд нь түйтгэрлэгдсэн үзэгч бусад бээр харахын цагт илбийн морь байгаа мөн хэмээнэ. Тэр үед илбэчин болон нүд нь ховсдогдсон үзэгч хоёрын талаас илбийн морийг талбиж болох бөгөөд эхнийх талбисан мэт шалгадаг ухаанаар бүтэх сүүлийнх нь талбисан мэтээр шалгадаг ухаанаар эс бүтэх. Бодгал тэр хоёрын чулууг морь хэмээн үзэх эрхтэний мэдэл нь илбийн морь агуулан үйлдэх шалгадаг ухаанд зохисгүй юм. Учир нь тэд хорлол үгүй оюун биш учраас. Тэр мөн юмаа. Хөндлөнгийн эндүүрэлээр түйтгэрлэгдсэн хорлолт оюун мөн учраас. Эрхтэнд хорлохын шалтгаан болсон гадна байгаа тарни, эм тэргүүтэй хорлол лугаа сэлтийн учраас. Албатай болой. Хөндлөнгийн түйтгэрийг танин барих үеийн *"Тийн номлолийн таалалыг машид тодруулагч"*-аас: Тэгүүнчилэн нүд хувилгагч тэргүүтэний найруулсан тарни хийгээд эм зэрэгтэй нийцүүлж үйлдээрэй

хэмээн зарлигласан юм. Тиймээс түүнийг зоригдон үйлдэж буй шалгадаг ухаан алин хэмээвээс нүд нь түйтгэрлэгдсэн үзэгчийн үндсэнд байхгүй болой. Түүний үндсэнд илбийн морийг илбийн мөнд оносон шалгадаг ухаан байхгүй тул. Тиймээс илбэчиний үндсэн дахь мэдлээс өөр бусадад зохисгүй. Тэр нь ч түүний үндэс дахь чулууг моринд үзэх эрхтэний мэдэл тэр нь шалгадаг ухаанд зохис үгүй болой. Тэр үзэгдэх орондоо эндүүрсэн буруу мэдэл болох учраас тэр. Тэгвэл алин хэмээвээс эрхтэний мэдэлийг даруйтын шалтгаанд үйлдэн төрсөн атхаг тэр нь илбийн морь агуулан үйлдэгч мөн. Атхаг түүний үзэх талаас морь үзэгдэж байгаа болохноо ч магадлах талаасаа морь биш гэдэг нь шийдэгдсэний эрхээр эндүүрсэн оюуны талаас үзэгдэл төдийд барагдахуйд атхаглаж байгаа юм. Товчилвоос бодгаль тэрээр илбийн морийг нүдний мэдэлээр харж буй бөгөөд үзэгдэл тэрчилэн морь бишийг атхагаар барж буй нь дамжиггүй ээ. *"Төв үзлийн гэгээ"*-гээс: Энэ мэт илбэчины мэдэлд заан тэргүүтэн тийн сэжигдэгсэд үнэндээ түүний чанар ямагт лугаа илтэд шунах үгүй болой. Түүнд илтэд шунасанаар үнэндээ түүгээр алслагдсан ямагтыг магадласан онол төрөхийн уг ямагтаар түүний оронт дор тийн агуулах болой ... гэсэн хийгээд *"Их бодь мөрийн зэрэг"*-ээс ч : Жишээ нь илбийн морийн үзэгдэлийг нүдний мэдэл бээр харах ба үзэгдэл адилын морь үхэр байхгүйг сэтгэлийн мэдэлээр магадлахад шүтээд морь үхэрт үзэх тэр нь илбийн буюу хуурамч үзэгдэл болохуйд магадлал төрөх тэгүүнчилэн дор... хэмээн зарлигласан. Үүгээр илбийн морь нь атхагаар талбигдсан атхаг нэрийтгэлд мөнд батлагдах буюу. Гэвч тэрхүү атхаг нь илбийн морийг морь биш гэдгийн агуулан үйлдэгч болохоос илбийн морь байгааг агуулан үйлдэгч болохгүй. Түүнийг байгааг алин бээр агуулах гэвээс Ловон Шиваанцо адил болбоос өөрийгээ ухахуй хийгээд Ловон Лигдэнжид адил болбоос эрхтэний мэдэл талбих буюу. *"Тийн номлолын таалалыг машид тодруулагч"*-аас: Тэр мэт үзэгдэл нь егүзэрийн явдалт төв үзэлтэн адилд өөрийгээ ухах илт мэдэл хийгээд гадаад утгыг баримтлагч өөрийн үндэст адилд газар зүг буюу завсрын үзэгдэл мэтийн суурийг барьсан эрхтэний илт мэдэлээр бүтэх дор хэмээн номлосон юм ... хэмээн зарлигласан учир. Иймд илбийн морь буй нь бүхэнд нэрийдсэн мөн учраас өөрийгээ ухах эрхтэний илт мэдэлээр шууд мэдэгддэг нь ч бус болой. Тэгвэл хэрхэх вэ хэмээвээс илбийн морийг барьж буй атхаг түүнийг анхааран амсагч өөрийгээ ухахуй бээр - би бээр түрүүн илбийн морь зоригдсон болой хэмээх оронт бээр орон лугаа зоригдсоныг дурьдах дурьдал өөрийн хүчээр татагдах учраас өөрийгээ ухахуйн хүчээр илбийн үзэгдэл байгааг батлаж болоход таалсан мөн. Жишээлбэл хоосон чанар байгааг үнэмлэхүйг ажиглах язгуур оюун үлэн мэдэлийг анхааран амсагч өөрийгээ ухахуй бээр дашрамд батладаг хэмээн номолсончилон болой. *"Үндсэн билгийн тийн номлол ухааны далай"*-гаас: Энд төв үзэлтэн нэрийтгэлд өөрийгээ ухахуй хүлээн зөвшөөрдөг учраас өөрийн чанар үгүйг шалгадагаар зоригдсон тэр зоригдон үйлдэгч анхааран амсагч өөрийгээ ухахуйгаар шууд бусаар батлах дор таалсан ч ... хэмээн зарлигласан. Энд шууд бусаар батлах гэдэг нь ч дашрамд жинхэнэ мэдэх бус ухаан түүний хүчээр мэдэхийн утга мөн. *"Үндсэн билгийн тийн номлол ухааны далай"*-гаас: Иймээс *"Тийн тайлбар"*-аас дуу нь үүдсэн мөн тэр адил бүхэн мөнх бус хэмээн өгүүлсэн ч утгаараа түүнд эвдрэхийн оюунд болох хэмээн утгаараа буюу хүчээр хэмээн номлосон ч дашрамд онох бус лугаа адил болой хэмээн айлдсан. Түүнчилэн Лигдэнжид дагуу болбоос нүдний мэдэлд чулуу моринд үзэгдэх ч зарим үед доод суурь дор шалгадагаар одох нүдний мэдэл төрөх нь ч байх учраас тэр адилын нүдний мэдэл бээр илбийн үзэгдэл байгаад магадлал өөрийн хүчээр татах мөн

буюу хэмээдэг. Гэвч түүний ёсонд зүүдэндээ заан зүүдлээд сэрэх үед тэр мэт зүүдэллээ хэмээн дурсах магадлал түүнийг татсан өмнөх оюун алин мөн гэхээр Ловон Лигдэнжидийн баримтлалыг номловоос “*Тийн номлолын таалалыг машид тодруулагч*” –аас: Номын төрөн түгэхүйд хамаарах дүрсийг сэтгэлээр мэдэх тул барин үйлдэх нэг зүүдэнд байгаа учраас тийн мэдэл нь орон үгүйгээр хаана ч үгүй болой хэмээн өгүүлсэн болой гэж гарсан адил зүүдний заан харсан зүүдний мэдэл буруу мэдэл мөн тул утга зохилдсон магадтай мэдэл татаж чадахгүй ч түүний хоёр дахь агшинаас зүүдний заан харсан сэтгэлийн илт шалгадаг төрөх бөгөөд түүний хүчээр тэр адилын магадлалыг татах болой. Энд үзүүлсэн сэтгэлийн илт нь үзээд эс магадлахуйд баримталдаг ухааныг даган барьсан сэтгэл төдийтэний тогтсон таалалтан мөн гэхэд гэм үгүй болой.

Дөрөв. ИЛБИЙН МОРЬ ҮХЭР ТЭРГҮҮТЭНИЙ МӨН ЧАНАРЫГ АЖИГЛАХ

Хэрвээ хэн нэгэн: Егүзэрийн явдалт мэтэд илбийн морь мэдэл мөн буюу тэр өөрийгээ ухах илт мэдэлээр батлагдах тул хэмээвээс тэгвэл Лхажингийн нүдний мэдэл чулууг морьд харах мэтээр жишвээс- Түүний нүдний мэдэлд үзэгдэх илбийн морь номтоо. Тэр Лхажингийн нүдний мэдэл мөн үү. Баримтлал чинь зохист буюу. Тийм. Тэр номт. Тэр Лхажингийн нүдний мэдэлд үзэгдэхгүй ээ. Тэр Лхажингийн нүдний мэдэл мөн учраас. Хэрвээ хэн нэгэн бээр дүрс мөн хэмээвээс. Бүдүүн дүрс үү нарийн дүрс үү. Бүдүүн хэмээвээс. Илбийн бүдүүн дүрс номтоо. Тэр эрхтэний мэдэлд харагдахгүй юу. Тэр эдэд эс бүтсэн учраас. Нарийн дүрс хэмээвээс. Эрхтэний мэдэлд магадлалыг татах хүчинд харагдахгүй юу. Дүрсийн хамгийн бага эцэс мөний тулд. “*Тийн тайлбар*” –аас: Эрхтэний орон тиймийн тулд нарийн тоос бус ... хэмээн зарлигласан. Бас нэгэн бээр: Судар аймгийн явдалт Төв үзэлтэн адилд илбийн үзэгдэл дүрс мөн. Газар, зүг тэргүүтэнг барьсан эрхтэний илтээр батлагдах гэвээс – Илбийн морь номтоо. Нүдний мэдэлд шууд харагдах тойм гадаад утга уу. Тэгсэн биз дээ. Тийм. Нүдний эрхтэний баригдхуун мөн үү. Нүдний мэдэлд шууд харагддаг баригдахуйн утга тойм ба хүрэлцэхүйн төрөн түгэхүй мөний тул. Тийм. Дүрсийн төрөн түгэхүй мөн болох уу. Зөвшөөрч байна уу? Зөвшөөрч байна гэвээс Ловон Лигдэнжид номт. Тэр хэтрүүлэгч Төв үзэлтэн болох уу? Илбийн морийг дүрсийн төрөн түгэхүйд зөвшөөрдөг их хөлгөний тогтсон таалалтан мөний тул. Энд алба буй болой. Илбийн үзэгдэлийг дүрсийн төрөн түгэхүйд зөвшөөрдөг нь хэтрүүлэгч төв үзэлтэн ямагтын онцлог мөн бөгөөд “*Тийн номлолын утгыг машид тодруулагч*” –аас: –Тэр нь ч гадаад утгад байгаачилэн хөрөг дүрс ч дүрсийн түгэн төрөхүйд таалдаг мөн бөгөөд доороос хөрөг дүрс бээр түүнийг харах эрхтэний мэдэлийг үүсгэдэг хэмээн бас зарлигласан болой. Эдгээр ёс нь нүдэнд морь мэт харагдах илбэ хийгээд хад тэргүүтэн дор ч бас мэдэж үйлдэх хэрэгтэй бөгөөд ёс энэ нь дээдэс эгүүний агуулга нийтийн бус мөн болой” хэмээн номложээ. Агуулга нийтийн бус хэмээсэн дор тийн тасалбар нэг байна. Энэ нь сайтар ойлгогдохоор байна. Мөн илбийн морь номт. Тэр даруйтын эндүүрэлээр түйтгэрлэгдсэн эрхтэний мэдэлд харагдахнаа ч түүгээр түйтгэрлэгдээгүй эрхтэний мэдэлд үл харагдах бусаа. Тэр нүдний шалгадаг мэдэл ухааны үзэгдэхүйн орон мөн байна ш дээ. Нотолгоог зөвшөөрөө биз дээ. Зөвшөөрч эс чадах буюу. Тэр адилын бодомж нэг байна. “*Илтийн бүлэг*” –ээс: Жишээ нь эрхтэн тав тэргүүтэн бээр түйтгэрлэгдсэн нагууд дор шавар чулуу тэргүүтэн тэгүүний дүрс лугаа хагацахнаа ч байдал өөр дор харахчилэн тэр нагууд нь эс түйтгэрлэгдсэн нүдтэн бээр тэр адил үзэх нь байхгүйн болой хэмээн

илт мөн дор Эс харах хувь нэг юу байх вэ хэмээн зарлигласан. Тиймээс—Хөх өнгийг барьсан эрхтэний илт мэдэл номтоо. Түүнд хөх өнгө төрөх нь харагдах уу. Түүнд хөх өнгө харагдах биз дээ. Тийм. Тэр номтоо. Түүнд хөх өнгийн төрөх нь үнэнд бүтсэнд харагдах уу. Түүнд хөх өнгө төрөх нь харагдах мөн тэр үнэний байдалд мөний тул. Тийм гэвээс зохист ухааны зүгээс үнэнд бүтсэн эс харагдах гэсэн баримтлал нь доройтох болой. Гэвч хөх өнгө үнэхээн баттай төрөх хийгээд хаагдах тэргүүтэнд харагдах баригдахуй нь олдмол үнэнд баригчийн баригдалийн орон учраас үнэн бүтсэний төрөх хийгээд хаагдах адилаар зохист ухааны зүгийн үнэнхуй бүтсэн нь эрхтэний мэдэлд эс үйлдэгдэх гэвээс болохоор хэмжээнд байгаагаар үл барам *“Тийн номлолын таалалыг машид тодруулагч”* аас: Илбийг үзэгч нүд нь түйтгэрлэгдсэн мэт амьтад гадаад юмс эдгээрийг үнэнд байгаагаар хараад..хэмээн ер нь амьтан нагуудад үнэнд харах байдаг гэж номлосон ч ялангуяа *“Донтүн”*-аас: Иймээс бодот нагууд санааны эрхэнд байх хийгээд амьтан бүхэнд бодот нагууд санааны эрхээр байгаа бус үнэхээрийн бодотын мөн чанарт байгаагаар эхлэл үгүй эндүүрэлийн авьяас огоот боловсорсон мунхагын эрхээр харж байгаад зарлигласан болой хэмээн амьтан бүхэнд үнэний үзэгдэл байгааг номлосон энэ нь *“Төв үзлийн гэгээ”*-н үгийн тайлбар дагуу нь илт бөгөөд тиймээс Шиваанцо эцэг шавийн ёсонд хоригдхуун үнэнд бүтсэн нь эрхтэний мэдэлд харагдах бөгөөд үнэнд бүтсэний төрөх тэргүүтэн эс харагдах гэсэн нь байж болохноо ч тэр адил болвоос мөн *“Тогтсон таалалын уулын үзэсгэлэнт чимэг”*-ээс ...хоёр үнэний тайлбарт үнэнд бүтсэний төрөх тэргүүтэн эрхтэний мэдэлд эс харагдахаар номлосон боловч... гэдгээс энэ нь егүзэрийн явдалт өөрийн үндэст төв үзэлтэнд ч бас адил юм. Богд Зонховын *“Орохуйн тийн их тайлбар”*-аас: ...үнэнд баригч тэрээр үнэхээр байгаа адил ойрд үзүүлсэнийг харах нь атхаг болохоос эрхтэний мэдэл бусаа. Хоёр үнэний тайлбарт хоригдхуун үнэнд бүтсэн нь эрхтэний мэдэлд үзэгдэхээр номлосон нь энд ч бас адил болой хэмээн Шиваанцо эцэг шавийн таалалыг номлохын үест зарлигласан болой. Тэр адил бус зохист ухааны талаас үнэхээр баттайд үйлдвээс үнэнд баригч тэрээр үнэнхүү байгаа мэтээр ойр үзүүлсэн хэмээх тэргүүтэний утгыг номлоход бэрх болох болой хэмээн зарлигласан лугаа шууд харшлахаар бодогдож байна. Товчилвоос хоригдхуун үнэнд бүтсэн нь эрхтэний мэдэлд харагдах бөгөөд зохист ухааны талаас үнэнд бүтсэн нь эс харагдах хэмээвээс *“Төв үзлийн гэгээ”*-гээс тиймээс ч амьтан бүхэнд үнэхээр бодотойн мөн чанарт адил ойр үзүүлсэнийг харах болох болой хэмээхийн харах тэгүүнийг эрхтэний мэдэлд номновоос авцалдаа тогтох хэмээх бөгөөд тэгвээс их Богд Зонхов бээр харах гэдэг нь атхаг болохоос эрхтэний мэдэл бусаа хэмээн зарлигласан нь ч утга үгүй болно хэмээсэн тул мэргэдүүд нарийн судлаад бусдад дэлгэрүүлэх зөв утганд хэлний эрхтэнээ алжааж хайрла.

Үргэлжлэл бий.